ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 17 өдөр Дугаар 83 Чойбалсан

Халдварын эрсдэлээс сэргийлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, $27^1$ дүгээр зүйлийн $27^1.1.1$, $27^1.1.2$, $27^1.1.4$, $27^1.2$, $27^1.3$ дахь заалт, Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйл, аймгийн Онцгой комиссын 2021 оны 58 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Халдвар бүртгэгдсэн болон халдварын тархалттай бүс нутгаас ирж байгаа иргэдээс авсан тандалтын шинжилгээгээр коронавируст халдвар (COVID-19)-ын батлагдсан тохиолдол эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.

1.1.Гэртээ зочин урихгүй, айлд зочлохгүй байхыг бүх иргэдэд даалгасугай.

1.2.Гэр бүлийн гишүүдээс бусад /хамт олон, найз нөхөд, гэр бүлийн гишүүнээс бусад ах дүү, хамаатан садан гэх мэт/ аялал, зугаалгыг зохион байгуулахгүй байхыг төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, хувийн хэвшил, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

1.3.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит газруудын харъяа амралт, сувилалын газруудын үйл ажиллагааг бүрэн хориглосугай.

1.4.Хувийн хэвшлийн иргэн, аж ахуйн нэгжийн амралт, сувилалын газруудыг орон тооны эмч, халуун хэмжигчтэй байж халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж, түргэвчилсэн оношлуурын нөөцийг бүрдүүлэн, коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлэх дархлаажуулалтын 2 дахь тундаа хамрагдаж бүрэн дархлаа тогтох 14 буюу түүнээс дээш хоносон иргэдийг хүлээн авах нөхцөлтэйгөөр үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсүгэй.

1.5.Хүний бөөгнөрөл үүсгэхээс урьдчилан сэргийлж төрөл бүрийн тоглоом /Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан гэмт хэрэг, зөрчлийн шинж агуулаагүй тоглоом болон бусад тоглоом/-ыг бүрэн хориглосугай.

2.Тогтоолыг иргэдэд мэдээлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Олон нийттэй харилцах албаны дарга Э.Батболд, аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Ч.Оюунаа, Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах, Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг, сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд бүх төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдэд мэдээлж, хэрэгжилтийг хангуулж ажиллахыг нийт сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт, тогтоолын хэрэгжилтийг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах, аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт тус тус үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбатад даалгасугай.

ДАРГА

ОРЛОГЧ ДАРГА,
ХУРАНДАА

ТҮ32695 0720030013 9029346